



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/390

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн
хуваарийг өөрчлөн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар, “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

2.Төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар /Ц.Ганцэцэг/-т, төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгохыг Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар /Б.Алтанцэцэг/-т тус тус даалгасугай.

3.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн сар, улирлын хуваарийг өөрчлөн батлах тухай” А/320, А/349 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.БАТЖАРГАЛ



1525011708

